


## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Доржсүрэн	Дугаар	L213
Оршин суугаа аймаг	Увс аймаг	Оршин суугаа сум	Хяргас сум
Төрсөн газар	Хяргас сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дэжээлин хийд	Сүм хийдийн дугаар	УВХГ 013
Одоогийн сүм хийд	Ганданшадавпэджээлин хийд	Сүм хийдийн дугаар	УВХГ 012
Ярилцлага авсан он сар өдөр	2007 он 6-р сарын 11	Ярилцлага авсан хүн	С.Билэг-Өрнөх



Увс аймгийн Хяргас сумын Дэжээлингийн хүрээ

Доржсүрэн: За тэгэхээр манай арван баядын хошуунд 1875 онд Дэжээлингийн хүрээ гэж байгуулагдсан. Цалгарын хүрээнээс тасарч байгуулагдсан ийм хийд байгаа. За Дэжээлингийн хүрээ бол тарах хүртлээ хоёр томоохон жастай, мянгаад ламтай байж байсан. Арван баядын одоо арван хошууг төлөөлж гол шүтээн болж байгуулагдсан түүхтэй байсан. Ингээд 1938 онд татан буугдаж тараагдсан. Лам нараас бол нэг 200, 300 хүн хэлмэгдсэн. Үлдсэн нь бол тэгээд артел энэ тэр хийгээд тэгээд өөр замаар явсан. Ингээд 1991 онд сүсэгтэн олны даалгавраар миний бие, Зудавын Баасанжав, Цэрэнжавын Баатар нарын хамтаар энэ сүм хийдийг сэргээн байгуулах босгох ийм даалгавар авч өөрснөө барьж байгуулсан түүхтэй. Үүнээс хойш жилийн хуралтай, жилд бурхан багшийн төрсөн өдөр, дүйчэн өдрүүд майдар эргэх ёслол үйл ажиллагааг тогтмол хийж заншсан ийм түүхтэй байна аа. За тэгээд ерэн онд энэ сүм хийдийг дахин сэргээж байх үед бол хуучин хүрээнд сууж байсан эрдэмтэй лам нар Сэд, Дандар, Дувдан тэргүүтэй арав гаран лам нар байж энэ хийдийг аравнайлж бидэнд бас эрдмээ зааж, өвлүүлж ингэж байсан бид баяртай байдаг. За одоогийн байдлаар хийдийн байдал бол боловсон хүчний хувьд дутуу л даа. За нэг 5 хүүхэд, ер нь 7 хүн сургасан боловч эрдмийн мөр хөөж Улаанбаатар, Энэтхэгт

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

шашны чиглэлээр сурч амьдарч байгаа. Хөдөө нутагт бол шашны боловсон хүчин дутагдалтай байдаг. Тэгээд энэ ажлыг бол олон түмний сүсэглэх бишрэх эрх чөлөөг хэрэгжүүлэх үүднээс бид бас зүгээр гар хүмхиж сууж боохгүй. Яахав хүсэлтийн дагуу бас үйлчилгээ явуулдаг, иймэрхүү байдалтай л ажиллаж байгаа ийм хийд байгаа. Манай хийд бол одоохондоо хурлын 4 ламтай. Байнга одоо яахав тогтмол дүйчэн өдрүүдэд хүрч ирээд суучихдаг дөрвөн ламтай. Өөр хүн байхгүй. Одоо нэг хоёр хүүхэд уг нь сурч байгаа, тэд бол унших хараахан болоогүй, ийм байна. Тэгээд алс хол нутагт сурах гээд очсон улсууд маань эрдмийн мөр хөөж тэгээд эргэж энэ хийддээ сайхан сэргээж авч явна байх гэж найдаж байгаа. За энэ манай хийд бол Баруун Монголдоо жахор цам дэглэж байсан одоо ерөөсөө цорын ганц хийд байгаа юм. Тэгээд бидний зорилго бол бас тэр уламжлалыг сэргээж энэ шашны жүжиг, шашны бүжгийг сэргээх ийм зорилго тавьж бас холбогдох байгууллагуудтай нь ярьж хэлж нутгийн зөвлөлтэйгээ санаа бодлоо солилцож ингэж ажиллаж байгаа. Ер нь ойрдоо бол сэргээх ийм бодлоготой, хойтон жил сэргээе гэж бодож байгаа. За нэг ийм зүйлүүд л байна даа.

Билэг-Өрнөх: За таньд баярлалаа.